



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№219 /428/ 2022.12.06

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ НЭГЖИЙН УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Орон нутгийн хамгаалалтын тухай хуулиар Завхан аймгийн Засаг дарга орон нутагт орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээдэг.

Энэ хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны захирамжаар орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг өнгөрөгч сарын 28-30-ны өдрүүдэд амжилттай зохион явууллаа.

Сургалтад хамрагдсан бүрэлдэхүүнд хөтөлбөрийн дагуу хичээл сургуулийг өдрийн 8 цагаар зохион байгуулан явуулж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлого, батлан хамгаалахын багц хуулиуд, Дайчилгааны болон Орон нутгийн хамгаалалтын хуулийн талаарх лекц, Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, томилгоот нэгжийн чиг үүрэг, зохион байгуулалтын талаар мэдээлэл өгсөн юм.

Орон нутгийн хамгаалалтын тухай хууль нь улс орныг батлан хамгаалах үндэс бөгөөд орон нутгийн хамгаалалтаар дамжуулж иргэдийг эх орноо хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх, эх оронч үзэл хүмүүжил олгох, тайван цагт иргэдийг орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд сургах, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг бүх шатанд хангах зорилготой.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-16	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.440	3.446
EUR	3.642	3.670
CNY	488	492
RUB	53.20	53.80
JPY	25.55	25.90
KRW	2.63	2.67

ЗУРХАЙ



2022.12.06 / МЯГМАР ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 14

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН
ГАХАЙ САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Эд мал арвидна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.26-17.00

Барилдлага:

Арвидах

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, сүм, суварга барих, хүүрийн газар эргэх, чуулан үймэхэд сайн. Нүд татваас эцэг эхэд аюул болох, баруун чих хангинавал эхнэртэй учрах, зүүн нь бол идээ ундаа олдох, нохой уливал гэнэт зочид ирэх болой. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ам болох, тагнай загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэмцэл болох, хөл татвал сайн.

ЧУУЛГАДАА ИХ ХҮНДЭТГЭЛ ӨРГӨВ



Мэргэжлийн урлагийн байгууллагуудын анхдагчдын нэг өдгөө 90 жилийн ойтойгоо золгож буй Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын үе үеийн уран бүтээлчид түүхт ойгоо угтаж "Чуулгадаа өргөх их хүндэтгэл" нэгдсэн тоглолтоор үзэгчдийнхээ сонор мэлмийг мялаалаа.

Энэхүү тоглолтод тус чуулгаас төрөн гарсан алдартан гавьяатнууд, үе үеийн уран бүтээлчид, өдгөө цагийн өнгийг тодотгон байгаа уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцсон юм. Чуулгын урын сангийн шилдэг бүтээлүүдийг ахмад, дунд, залуу үеийнхэн хамтдаа амилуулж, алтан тайзнаас шимтэн үзсэн үзэгчид халуун алга ташилтын хурыг буулгаж бахархал, бахдалаар дүүрэн цалгилаа.



САНХҮҮГИЙН АЖИЛТНУУД АЛБАНЫХАА ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАВ




Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн санхүүгийн албаны ажилтнууд Монгол Улсад Санхүү, бүртгэлийн салбар үүсэж хөгжсөний 111 жилийн ойг тохиолдуулан санхүүгийн мэргэжил, албыг сурталчлах өдөрлөгийг зохион байгууллаа.

Энэхүү бүтээлч ажлын хүрээнд хугацаат цэргийн алба хаагчдад санхүүгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсны зэрэгцээ тэдний амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Сагсан бөмбөг"-ийн тэмцээнийг явуулж манлайлсан баг, тамирчдыг шагнаж урамшуулсан юм.

Мөн тус ангийн офицер, ахлагч, ажилтан албан хаагчдад "Цалин, хөлсний тухай" сэдвээр санхүүгийн албаны дарга ахлах дэслэгч М.Оюумаа, "Үнэт цаасны зах зээл", "Монголын хөрөнгийн зах зээлд хуримтлал үүсгэх боломж" сэдвээр "Stocklab" санхүүгийн байгууллагын мэргэжилтэн Н.Анударь нар мэдээлэл хийж, бие бүрэлдэхүүнд санхүүгийн мэдлэг олголоо.

Төгсгөлд нь нийт бие бүрэлдэхүүний дунд танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг зохион байгуулж өргөмжлөл, гарын бэлэг гардуулав.

Хошууч С.БАТБААТАР



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 650,241,482

Эдгэрсэн

Нийт: 627,250,229

Нас барсан

Нийт: 6,647,667

Цахим шууданд

ХЯЛГАНАТ ТОСГОНЫ УРЛАГИЙН НААДАМД УСЧИН ДАЙЧИД ТЭРГҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 234 дугаар анги

Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг урлагийн наадам энэ сарын 3-ны өдөр амжилттай болж өндөрлөлөө.

Хамтын ажиллагааг бэхжүүлэх, урлагийн гоо зүйн мэдрэмжийг олгох олон талын ач холбогдолтой тус наадамд 10 гаруй байгууллагын төлөөлөл оролцож авьяас чадвараа сорин өрсөлдөхөд багийн дүнгээр тэргүүн байрт Зэвсэгт хүчний 234 дүгээр анги, дууны төрөлд тус ангийн соёл хүмүүжлийн офицер, дэслэгч Ч.Оюунчимэг нар тус тус тэргүүлсэн юм.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ



БАЙЛДАГЧИЙН ЭЭЖЭЭС ЗАХИДАЛ ИРЭВ



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын хаягаар Өвөрхангай аймаг Уянга сумаас "Байлдагчийн ээжээс" хэмээх өгүүлэмжтэй нэгэн захидал ирлээ. Захидлыг задалж үзэхэд иргэн Ц.Оюунжаргалаас бөгөөд тэрээр Зэвсэгт хүчинд хугацаат цэргийн алба хааж байгаа хүүгээрээ бахархаж, анги хамт олноор нь талархаж буйгаа өгүүлжээ.

...Сайн байна уу. Та бүхэндээ захидал очих өдрийн мэндийг уламжилж, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. "Хүү төрүүлбэл хилээ манах, охин төрвөл галаа манах нь" хэмээн ерөөлөөр бэлгэдэж хэлдэг монгол ёс байдаг билээ. Намайг Ц.Оюунжаргал гэдэг, жирийн нэгэн монгол

ээж. Эх орондоо, төрдөө итгээд хүүгээ эр цэргийн албанд мордуулсан эмэгтэй. Харин миний хүүг Б.Билгүүнтөгс гэдэг, Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч. Яг үнэндээ сошиал сүлжээгээр явж байгаа мэдээлэлд хэт итгэсэндээ ч тэр үү жаахан айдастай л байсан. Энэ үзэл бодол хүүгийнхээ цэргийн тангараг өргөх өдрөөр нь Өмнийн говьд очоод ямар их өөрчлөгдсөн гээч. Хүү минь өмнөхөөсөө ч илүү цог золбоотой сүр жавхлантай сайхан залуу болж. Ердөө 40 хэдхэн хоногийн дотор шүү дээ. Энэ бол цэргийн албаны сүр хүч, өнгө жавхаа байх.

Энэ замналаар явсан залуусыг "Цэргийн хүн жаргалд ташуурдаггүй,

зовлонд гунддаггүй" гэж хэлсэн нь ч зөв санж. Хүүгээ жагсаалын талбай дээрээ онжавуудтайгаа яг л нэг хүн шиг тэвхийтэл ёсолж, тугандаа мөргөж, тангараа уншиж байгааг аав, ижий хоёр нь хараад баярын нулимстай, талархлын сэтгэлтэй зогсож байснаа нуух юун. Яг л бид хоёр шиг олон аав, ээж, ахан дүүс, найз нөхөд тэгж баярласан. Хүүгээ, дүүгээ, найзыгаа, ахыгаа ямар сайхан жавхаажсаныг хараад тэр. Тэр өдөр бас хүүгийн минь төрсөн өдөр болсон. Аав бид хоёр нь бялуу тэврээд очсон ч анги, хамт олон нь түүнээс ч илүү том бэлэг барьж, баярлуулна лээ.

Цэргийн алба нь ажил, амьдралаа аваад явах тэсвэр хатуужил, эх орон, ард түмнээ хайрлаж дээдлэх итгэл үнэмшил, хүнд хэрэгтэй сайн чанар бүхнийг төлөвшүүлэх шалгарсан арга, хосгүй сургалт. Хүүгээ сайн хүн болгохын тулд үеийн үед уламжлан хэрэгжүүлж ирсэн манай өвөг дээдсийн нандин өв гэдэг нь үнэн юм байна. Цэргийн дарга нар болсон офицер, ахлагч нар ч харилцаа сайтай, мэнд устай хүүхдүүд байна лээ. Иргэнийхээ хувьд Зэвсэгт хүчиндээ талархаж энэхүү захидлыг бичиж байгаа нь энэ. Цэргийн алба аав, ээж бидний төсөөлж байснаас ч илүү сайхан орчин юм байна. Баярлалаа. Монгол цэргийн яруу алдар үеийн үед мандан бадрах болтугай" хэмээжээ.

Ахмад Д.БОЛОР

БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАЖ БАЙНА



Завхан аймгийн Засаг даргын 2022 оны захирамжийн дагуу 24 сумын дайчилгааны болон орон нутгийн цэргийг байгуулах, бэлтгэлийг хангах төлөвлөгөөг батлуулах ажлыг өнгөрөгч сарын 30-ны өдөр зохион байгууллаа.

"Сумдын дайчилгааны болон орон нутгийн цэргийг байгуулах, бэлтгэлийг хангах төлөвлөгөө"-г боловсруулах ажлыг 2022 оны 4 дүгээр сараас эхэлсэн бөгөөд явцын хяналтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб хариуцан зохион байгуулав. Энэхүү төлөвлөгөө батлагдсанаар орон нутагт батлан хамгаалах тогтолцооны удирдлагын баримт бичиг бүрдэж байгаа юм.


Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №31

УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА

Өмнөх хичээлээр үзсэн ГА, ГЭ гийгүүлэгч бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүйлэн бичиж, кириллд хөрвүүлээрэй.

Дармал, бичмэл тигээр:



Зарлал

"АЛДАР" СПОРТ ХОРОО



ХҮНДИЙН ӨРГӨЛТИЙН ДУГУЙЛАНД ХҮҮХЭД, ЗАЛУУСЫГ БҮРТГЭЖ БАЙНА.

УТАС: 89893777, 80420002 FB: Cch Mart, Ulaanaa Otgonjargal ХАЯГ: БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, ДАНДАРЫН ГУДАМЖ, ОФИЦЕРУУДЫН ОРДОНЫ АРД

Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилготой хүүхэд, залуусыг хүндийн өргөлтийн дугуйланд бүртгэж байна